

**Жүрчин ба манжийн зарим цол хэргэмийн учир  
/хэлний судалгаа/**

**М.Баярсайхан\***

0. Оршил

1. Жүрчиний цол хэргэмийн зүйл

2. Манжийн цол хэргэмийн зүйл

0. Аливаа үндэстэн угсаатны төрт ёсны түүхэн дэх цол хэргэм, албан тушаал, зэрэг дэвийн нэрс нь тухайн үндэстний нийгэм соёлын түүхийн өвөрмөц онцлог хийгээд тэрхүү үндэстэн угсаатнаас бусад улс үндэстний түүх соёл лугаа хэрхэн холбогдсон байдлыг илтгэх нэгэн талын сонирхолтой хэлний баримт, хэл түүх соёлын судлагдахуун билээ.

Алс Дорнод, Зүүн хойд Азийн ард түмнүүдийн улс төр, соёлын түүхэнд жүрчид буюу манж нар онцгой байр эзэлдэг. Үгийн утга, гарал үүслийг тодруулах нь түүхэн харьцуулсан судалгаа тул зөвхөн жүрчин, зөвхөн манж нарт хамааруулан түүхэн дэх цол хэргэмийг авч үзэх нь өрөөсгөл юм. Иймд, Алтан улс болон түүнээс өмнөх үеийн жүрчин нар, тэдний өвөг дээдэст холбогдох түүхийн мэдээ баримтыг Дай Чин улсын үе хүртэл хамтад нягтлан үзэх нь зүй. Гэхдээ тухай тухайн төр улсын бүх цол хэргэм, албан тушаалыг улс төр, цэрэг-засаг захиргааны нь байгууламжтай харгалзуулан иж цогцоор нь нягтлан үзэх явдал түүхийн тусгай нэг сэдэвт бүтээлийн хэмжээнд гаргах асуудал юм. Энэхүү өгүүлэлд, жүрчин-манж хэлтний өөрийн нь /гарлын хувьд уугуул болон дундын үг/ гэж үзсэн зарим цол хэргэмийн нэрийн талаар санал нэмэрлэхийг зорив.

**1. Жүрчин нарын цол хэргэмийн зүйл**

“Алтан улсын судар” (金史): <<Алтан улсын уг нэр Нюйчжи. Нюйчжи улс угтаа Мохэ<sup>1</sup>-

\* Монгол Улсын Их Сургууль, Монгол хэл, Соёлын Сургууль

<sup>1</sup> Хятад бичигт 鞑靼, солонгос бичигт 말 갈 хэмээн тэмдэглэнэ. Мохэ бол Манжуур дахь эртний түнгүс угсаатан бөгөөд зарим судлаач “мохэ” гэдэг нь голоор нутаглагч гэсэн утгаар нэрийдсэн түнгүс үг гэж үздэг. Бас зарим судлаач Мохэ-гийн нэрийг (motkid, malgal, mokher, mogher, maka гэх зэрэг хувилбар дуудлагатай) Монголын Нууц Товчоонд гарах “mergid” аймгийн нэр болон мэргэн хэмээх үгтэй холбон тайлбарлах нь ч бий. Солонгос сурвалжид “мальгаль” гэсэн дуудлагаар тохиолдоно. Ж.Сюэюань Чжу бээр улмаар мажар “magyar” гэдэг угсаатны нэртэй холбожээ.

гээс гарав. Мохэ-гийн уг нэр Үжи (Wuji, 勿吉). Үжи эртний Сушэнь (Sushen, 肅慎)-ий газар мөн. Юань Вэй хааны<sup>2</sup> үед Үжи газарт сумо (粟末)<sup>3</sup>, бодо (伯咄), аньчэгү (安车骨), фүнией (拂涅)<sup>4</sup>, хаоши (號室)<sup>5</sup>, хэйшүй (黑水)<sup>6</sup>, байшань (白山)<sup>7</sup> хэмээн долоон аймаг бүлгээ. Юань Вэй хэмээх нь Вэй улсын<sup>8</sup> Тао Гуй<sup>9</sup>-гийн үр. Жинь (晉朝)<sup>10</sup> улсын эцсийн үед гарчээ. Дайляо (大遼朝)<sup>11</sup>-гийн адил өөр улс ажгуу.>> хэмээн эхэлдэг.

Энэ нь товч боловч жүрчин нарын гарал үүслийн тухай магадтай мэдээ болохыг нангиад сурвалжийн бусад мэдээ нуталдаг. Сушэнь (肅慎)-ий талаархи хамгийн эрт үед холбогдох мэдээг “*Шицзи*” (史記) буюу “*Түүхэн тэмдэглэл*”-д бичжээ. Тэр мэдээгээр ХТӨ<sup>12</sup> 2021 онд буюу Хятадын эртний домгийн хаан Шунь(舜)-ий үед Сушэнь аймгийн элч чулуун зэв бүхий сум бэлэглэсэн гэжээ. Энэ мэдээг түүхэн үнэн бус, домгийн чанартай зүйл гэж үздэг. Мөн сушэнь нар Чжоу (周朝)<sup>13</sup> улсын хаанд буга, хандгайгаар бэлэг барьж явсан, Сүмбэ (Сяньби 鮮卑) нарын эсрэг тэмцэж байсан, “*Хожуу Хан улсын судар*” (後漢書) болон “Вэйчжи” (魏志)<sup>14</sup>-д сушэнь нарын хэлний тухай дурдсан зэрэг бас бус холбогдох мэдээг нангиад түүхийн сурвалжид тэмдэглэн үлдээжээ. Сушэнь-ийг бас “илоу (yilou 挹婁)” гэсэн байдаг. 4 дүгээр зуунаас хойш хятад сурвалж бичигт сушэнь хэмээх нэр тохиолдохоо байж, Умард Вэй улсын үеэс “үжи (wuji 勿吉)”<sup>15</sup>, Суй улсын (隋朝) үеэс “мохэ” хэмээх нэрээр тэмдэглэж байв. Мохэ нар нь эртний Пуйё (со. 부여, хят. 餘)<sup>16</sup> улсын бүрэлдэхүүнд багтаж асан хэмээх ба 1-2 дугаар зууны үед Пэкже (со. 백제, хят. 百濟)<sup>17</sup>, Шилла (со. 신라, хят. 新羅)<sup>18</sup> зэрэг улс мохэ лугаа байлдаж байсан тухай тэмдэглэл бий.

Харин эдгээр жүрчиний дээд үеийнхэнд холбогдох цол хэргэмийн нэр төдий л тэмдэглэгдсэн зүйлгүй. Гагцхүү 477 онд Табгач Сяньби угсааныхны байгуулсан Умард Вэй улсын Сяо Вэнь-Ди (Xiao Wen Di 孝文帝)<sup>19</sup> хааны ордонд Үжи-гийн элч *Иличжи* (I-li-zhi, 乙力支) түшмэл бараалхсан хэмээх нэгэн мэдээ байна. Үүнийг Японы эрдэмтэн Вада Сэй анхааран

<sup>2</sup> Умард Вэй улсын хаан Сяо Вэнь Ди улс үндэстэнээ хятаджуулах бодлого явуулж, 496 онд Тоба овгоо Юань 元 хэмээн халснаас хойш дараа дараагийн хаад бүгд юань овогтон болсон ба Табгач Сяньби-гийн улсыг түүхэнд бас Юань Вэй (Yuan Wei /元 魏/) гэх болжээ. Энд Юань Вэй хаан гэсэн нь Сяо Вэнь Ди хааныг хэлж буй.

<sup>3</sup> Сунгари мөрний саваар нутаглаж асан мохэ аймаг. Сунгари мөрнийг сумо шуй хэмээн тэмдэглэж байжээ.

<sup>4</sup> Муданьцзян голын орчим нутаглаж байжээ.

<sup>5</sup> Бодо, аньчэгү хоёр мохэ аймаг хаоши-гийн мохэ аймагт харьяалагдах болсон ба Гуулин улс дийлдсэний дараа эдгээр мохэ нар Бохай улсад дагаж орцгоожээ.

<sup>6</sup> Мохэ нарын дотор хамгийн хүчирхэг нь байсан тэд Хар мөрөний сав газар нутаглаж байв. “Бүдүүлэг нюйчжи” гэгдэж байгаад Алтан улсыг байгуулсан жүрчин нарын дээдэс болно.

<sup>7</sup> Урт цагаан уулаар нутаглаж байв. Байшань буюу цагаан уул гэсэн нь Чанбайшань уулыг заажээ.

<sup>8</sup> Умард Вэй буюу Тоба Вэй (拓拔魏) (386-534 он) улс.

<sup>9</sup> Вэй улсын анхдугаар хаан болох Тоба Гуй /тахилын өргөмж нь Дао У Ди/ нь 386-409 онд төр барьжээ.

<sup>10</sup> Гурван улсын дараа байгуулагдсан Хятадын төр улс. ХТ-ын 265-420 онд тогтножээ.

<sup>11</sup> 907-1125 онд тогтножээ. Бас Хятан гүрэн (契丹 國) гэнэ.

<sup>12</sup> Христийн тооллын өмнөх

<sup>13</sup> ХТӨ 1122-256 онд тогтнож байв.

<sup>14</sup> “Гурван улсын түүх”-ийн доторхи “Вэй улсын тэмдэглэл” буюу. “Вэй шу” сурвалжтай андуурч үл болно.

<sup>15</sup> Үжи гэдэг нь хэйшуй мохэ нарыг тэмдэглэсэн өөр нэрийдэл мөн гэж судлаачид үздэг.

<sup>16</sup> ХТ. II зуун-494 онд оршин тогтнож байв.

<sup>17</sup> ХТ.18-660 онд оршин тогтножээ.

<sup>18</sup> ХТӨ.57- 935 онд оршин тогтножээ.

<sup>19</sup> 471-499 онд Умард Вэй улсын хаан сууринд суужээ.

үзэж “*иличжи*” хэмээх нь манжийн “*elčin*” гэсэн үг мөн гэж үзсэнийг академич В.Е.Ларичев дэмжжээ<sup>20</sup>. “*Elčin*” гэдгийн “*el-il*” үндэс нөхөр, дотно, харь бус гэсэн утгат эртний монгол үг бөгөөд мо. *elige(n), eligeseg, Il qan, elseg, else-, elberi-* зэрэг олон үгийн үндэс мөн. Цаашилбал, язгуур нь “*e-*” болох бөгөөд *eu-e, eb, enegsi-*; ма. *elhe* “энх”, *elbi-* “элсэх” зэрэг үг гарал нэг юм. Хэдий үндэс язгуур нь монгол ба манж-түнгүс хэлний дундын махбод байвч, чухам –*čin* дагавар залгаж бүтсэн “*elčin*” гэдэг хэлбэр бол монгол хэлнээс жүрчин (жү<sup>21</sup>. 𠵹𠵹 *eči*), манж хэлэнд орсон үг гэж үзэлтэй. Хэрвээ “*иличжи*” нь “*элчин*” гэдэг үг мөн гэсэн дээрх эрдэмтэдийн саналыг дэмжвэл, наанадаж 5 дугаар зуун буюу Нирун (柔然) улсын үе гэхэд эртний өмнөд түнгүсийн хэлэнд монгол хэлний “*elčin*” хэмээх үг орсон хэрэг болно.

Үүнээс гадна хятан хэлний *i-li-chin* гэдэг үгийг холбогдуулж болох өөр нэгэн санал байж болох юм. Хятан(契丹)-ы Елюй Амбагай<sup>22</sup> хаан Тан улсын (唐朝)<sup>23</sup> Тянь-фу (天福)-гийн анхдугаар онд (ХТ.901 он) өөрийн аймагтаа “*иличжин*” (*i-li-chin*) түшмэл болсон ба тэрхүү хятан хэлний “*иличжин*” хэмээх нь цэрэг захирагч их ноён гэсэн үг<sup>24</sup> хэмээн “Ляо ши (遼史)”-д тайлбарлажээ. Л.Л.Викторова авгай “*i-li-čhi*” хэмээхийг “*il ejen*” гэсэн үг гээд хожмын 13-14 дүгээр зууны Монголын Ил хаан (*Il qan*)-тай харьцуулсан байна<sup>25</sup>. Судлаач Жэймс Сюэюань Чжу бээр *I-li-zhi* (乙力支)-гээс гадна *I-li-gui* (俟力歸), *Ni-ru-li-ji* (倪屬利稽), *To-di-ji* (突地稽) зэрэг Мохэ-гийн сурвалжтаны нэр нангиад сурвалжид байдгийг дурдан эдгээр үгийн “*zhi*”, “*gui*”, “*ji*” зэрэг төгсгөл нь тэргүүн, эзэн, ахлагчийг заах цол тушаалтай холбогдоно<sup>26</sup> гэжээ. Манж хэлний нийлмэл үгийн зүйлд *banaji* (*ba-na-ji*) “газар орны эзэн”, *boiyoji* (*boiyon-ji*) “гэрийн эзэн” гэх зэргээр эзэн гэдэг үг хураагдан “-ji” хэлбэртэй болсон байдаг. Үүнчлэн үнэхээр мохэ нарын *i-li-zhi* –гийн төгсгөл –*zhi*, хятаны *i-li-chin* – ий төгсгөл – *chin* хийгээд мо., ма. , тү. “*ejen~ejin*”-ий *-ji/n/* нэг л бүтээвэр байхыг үгүйсгэхгүй. Ийнхүү үжи аймгийн элч Иличжи хэмээх нь хэрвээ оноосон нэр биш, ямар нэгэн цол, тушаалын нэр бол тэр нь эртний монгол ба хятан хэлтэй дам холбогдох боломжтой ажээ.

Гэвч, хятаны “*i-li-chin*”-ий эртний дуудлага “*i-li-kin ~ i-li-gin*” байсан гэж үзэх нь зүйтэй<sup>27</sup>. Хятадын эрдэмтэн Линь Ган-гийн бичсэн “*Дунхугийн түүх*”-ийн монгол бичгээрхи хэвлэлд “*ilig*” гэж бичжээ. Тэр “-*gin-kin*” төгсгөл нь Алтай язгуурын хэлт умардын нүүдэлчдийн “*tigin-egin-ekin*”, “\**pekin*”, Табгачийн зонхилогчийг нэрлэх “*түйин*”, Пуйё аймгийн ахлагч “*те-ин*” зэрэг цол тушаал заасан үгийн *-kin ~ gin* төгсгөл лүгээ нэг байж мэднэ.

<sup>20</sup> В.Е.Ларичев, *Краткий очерк истории Чжурчжэней до образования Золотой империи: История Золотой Империи*, Новосибирск 1998, 52 с.

<sup>21</sup> Жүрчин бага бичигт хэрхэн тэмдэглэснийг дурдахдаа жү. гэсэн товчлол хийв.

<sup>22</sup> Сурвалж болон түүхийн утга зохиолд Амбаганы, Абаки, Амаки, Абоожи(阿保機) гэх мэт олон хувилбараар тэмдэглэжээ. Үүнийг МНТ-д гардаг Амбагай хаан, манжийн Тайцзун хуанди Абахай нарын нэртэй утга гарал ижил, эртний нэр гэж бодож байна.

<sup>23</sup> ХТ.618-907 онд тогтнож байв.

<sup>24</sup> Энэ тайлбар нь хятан үгийн үгчилсэн орчуулга бус, харин эртнээс нааши хятадын “цэргийн үйлийг бүгд захирагч түшмэл” тушаалтантай дүйлгэсэн тайлбар бололтой.

<sup>25</sup> Л.Л.Викторова. *Монголы. Происхождение народа и истоки культуры*. М.1980, с 233. /Тус номын 152 дугаар талд үзнэ үү./

<sup>26</sup> James Hueyuan Zhu, *The Far-East Ancestors of the Magyars: A Historical and Linguistic Excavation*; International Journal of Central Asian Studies, vol 4, 1999, ISSN 1226-4490.

<sup>27</sup> Үлгэрлэвээс, “*ki-tan*”(хятан) хэмээхийг хожим “*či-dan*”, “*ging*”(нийслэл хот) хэмээхийг хожим “*jing*” гэдэг болсон мэт.

“*ejen*” хэмээх үг бол цол хэргэм, зэрэг дэвд зайлшгүй холбогдуулж үзүүштэй эртний үг юм. Уугал утга нь бөөгийн шүтлэгт холбогдох эртний соёлын энэ үгийг манж түнгүс, монгол, түрэг хэлтэн эртнээс нийдэм хэрэглэсээр иржээ. С.А.Старостин нарын сэргээснээр Tung. \*edī; Turk. \*edi, Mong. *ejen* хэлбэртэй<sup>28</sup> бөгөөд түнгүсийн хэлнүүдэд 1. эр хүн, 2. эзэн, 3. ноён, 4. амьтны эрэгчин, 5. өрхийн тэргүүн, 6. ахлагч, захирагч, 7. аливаа юмны далд эзэн (сүнс) гэх мэт олон утга илтгэдэг байна. Монгол хэлний “эзэн” гэдэг үгийн эртний хэлбэрийг ч бас *ejen*→*ejin*→\**edin* гэж сэргээх нь маргаангүй. Эртний “\**edi/n*” (эз) гэдэг үг монгол, түрэг хэлний *ed* “эд”-тэй язгуур нэг, цаад учир нь шүтлэгийн эртний хэлбэр болох амьдчилал (анимизм)-тай холбоотой байна. Өөрөөр хэлбэл, “*edi/n*” хэмээх нь “эд юмсын дотоод нууц ид, ер бусын хүчин”-ийг зааж байснаа, аандаа “*eje*” (эз) гэдэг үгийн утгын хийсвэрлэл нь нарийсч << хүний биед эзэн болж элдэв муу хэргийг үйлдүүлж байх далдын хүчин >><sup>29</sup>-ийг заасан утгатай болсон байна. “Эз”-ийг чанга эгшгээр сэлгүүлэн “аз” (*aja*) гэсэн үг үүсчээ<sup>30</sup>. Монголчуудын “эз татах”, “эз хатгах”, “эз дийлэх” гэсэн хэллэгээс уг утга нь тодорхой мэдэгдэнэ.

Жич, “Жүрчин үгсийн хураангуй” буюу “*Nüzhēn Guan Za Zi*” (女真馆杂字) гэдэг дурсгалд эзэн гэсэн утгатай Г.Н.Кийосэ (G.N.Kiyose) “*giyun*” (“sovereign”)<sup>31</sup>, Хэшигт “*dzyn*” гэж<sup>32</sup> тус тус галигласан (жү. 纛) хэмээх үсэг бий. Үүнийг мөнөөхөн *ejen*→*ejin* гэдгийн -*jin* төгсгөлтэй хутгаж болохгүй. (жү. 纛) бол хятад хэлний 君 (*jūn*) гэдэг үг бололтой. Мөн дурсгал дахь [жү. 兵中旆旻并]\**cau-ha e-je-hei* гэдэг үгийг Г.Н.Кийосэ “military commission (gen.?)” буюу “цэргийн эрх мэдлийн” гэж орчуулжээ<sup>33</sup>. Энд харин Алтай хэлтний “*ejen*” хэмээх уугал үгийн язгуур хэвээр байна.

“*mergen*” хэмээх монголд түгээмэл хэрэглэж байсан цолын учрыг нягталж үзвэл, энэ үг түрэг хэлнүүдэд тохиолдохгүй, харин монгол, түнгүс хэлний дундын үг ажээ. Манж-түнгүсийн хэлнүүдэд эвенк. мэргэнчи, сол. мэргэ, нег. мэжүн, ороц. мэггэ, уд.мэргэ, ульч. мэргэ/н/, орок. мэргэ/н/, нан. мэргэ, манж. *mergen* зэрэг хэлбэртэй, баатар, эрэлхэг, чадамгай, онч мэргэн, цэцэн гэх мэт хэд хэдэн утга илтгэдэг<sup>34</sup> аж. Түнгүсийн үлгэр домогт мэргэн цолтон цөөнгүй тохиолдоно. Ан гөрөө эрхлэгч ард иргэдэд мэргэн хэмээх нь эртнээс сайн харваач гэсэнтэй ойролцоо утгаар хэрэглэгдэж иржээ. Зарим судлаач жүрчин угсааны “*mohe*” болон “*wuji*”, МНТ-д гардаг мэргид аймгийн “*mergid*” хийгээд мөнөөх “*mergen*” цолын нэр нь харилцан холбогдох нэг үгс гэж үзэж байна. Хөшөө цайдамын руни бичгийн дурсгалд гардаг “*bukli chul*”-ийн “*bukli*” зэрэг угсаатны нэр ч *merkit* ~ *mekrit* > *mukrit* > *bukli* хэмээн холбогдох боломжтой мэт санагдана.

<sup>28</sup> S.A.Starostin. A.V.Dybo, O.A.Mudrak. *An Etymological Dictionary of Altaic Languages*, see 493p.

<sup>29</sup> C.Norjin., *Mongol helen-ü toli. öbür mongyol-un arad-un keblel-ün qoriy-a.* 1999. 268 t.

<sup>30</sup> Аз ба эз нь гарал нэг атлаа эерэг сөрөг үнэлэмжийн талаас нь үзвэл эсрэг утгат үг үүсгэжээ. Гэхдээ энэ эсрэг утга гэдэг нь харьцангуй ойлголт. Учир нь, “эз” хэмээх нь утгаа бол ер далдын хүчнийг бишрэхтэй холбоотой, хийсвэр ухагдахууныг тэмдэглэж байна. Харин дангаар бус хэрэглэгдэхдээ “эз”-ээс эмээж, элдэв гай гамшигт түүнтэй холбон тайлбарласан холбоо үг болон тогтворжжээ. “Аја” нь харьцангуй хожмын утга салж үүссэн үг юм.

<sup>31</sup> G.N. Kiyose, *A Study of the Jurchen Language and Script*, Kyoto, 1977, [260 pp], See: p. 112.

<sup>32</sup> 道尔吉, 和希格, 女真译语研究, - 内蒙古大学, 学报, (1983), 北京 [437 pp], see: p.293.

<sup>33</sup> G.N. Kiyose, *A Study of the Jurchen Language and Script*, Kyoto, 1977, [260 pp], See: p. 112.

<sup>34</sup> *Сравнительный словарь тунгусо-маньчжурских языков. Материалы к этимологическому словарю.*, Ответственный редактор В.И.Цинциус, Т 1 (А-Н), Ленинград 1975, 672с; Т2 (О-Э) Ленинград 1977, 979с. /тус номын тэргүүн дэвтрийн 571 дүгээр талд үзнэ үү./

Жүрчий нарын цол хэргэмийг гарлгынх нь хувьд 1. уугал хэлний, 2. харь хэлний гэж ангилж болно. Харь хэлний цол хэргэмийн нэрэнд Тан улс, Өмнөд (南宋)<sup>35</sup> ба Хойд Сүн (北宋)<sup>36</sup>-гийн улс төрийн харилцаа, соёлын нөлөөгөөр орж ирсэн нангиад голдуу гаралтай үг бий. Мохэ нарын аймгийн ахлагчид хятад цол тушаал их хүртэж байв. Тухайлбал, Тан улсын үед нэлээд хүндтэйд тооцогдож байсан тайши цол авсан жүрчин ноёд нийт 70 гаруй хүн лавтай буй гэсэн судалгааг Японы эрдэмтэн Торияма Кинти гаргажээ. 10 дугаар зуунаас хятанчууд хүчирхэгжихийн хамтаар Ляо улсад хэрэглэж асан мөн л нангиад гаралтай цол тушаалыг жүрчиний тэргүүдэд өгч байв. Ялангуяа одоогийн Гирин муж, далайн эрэг хавиар нутаглан Ляо улсын харьяат гэж тооцогдож байсан бүдүүлэг нюйчжи-гийн газар хятанчууд өөрийн түшмэлийг томилохгүй, харин тэдгээр аймаг овгийн тэргүүн нарын дотроос итгэл хүлээхийг нь харгалзан цыши (刺史), цзедуши (節度使), дутун, да ван (大王) гэх мэт цол тушаалтныг тавьдаг байжээ. Урьдын Тан улсын үед хил хязгаарыг байцаан сахих түшмэлийг “цзедуши” гэж байсныг Ляо улсын үед “тайши” гэх болов. “Алтан улсын судар”-ын тэргүүн дэвтэрт: << Дайляо улсын хаан бээр Угунайг авчирч, ихэд шагнаад түшмэл нэмж, бүдүүлэг нюйчжи улсад цзедуши түшмэл болгов. Цзедуши хэмээх нь нэгэн мужийг эзэлсэн түшмэл буюу. Дайляо улсын хүн цзедуши-ийг тайши хэмээмүй. Нюйчжи улсын хүн ду-тайши хэмээсэн нь түүнээс эхлэв.>> гэх мэтээр бичжээ. Алтан улс байгуулагдсан хойно ч гэсэн хятад иргэнийг өөрийнх нь хэвшил журмаар захиран эрхшээх бодлого, өмнөх Ляо улсын туршлагаас үлгэр авах зэрэг зайлсхийж үл болох бодот шалтгааны улмаас Алтан улс цэрэг-засаг захиргааныхаа зохион байгуулалтад бичиг ба цэргийн түшмэлийн уламжлалт хятад цол тушаалын нэрийг үлэмжхэн хэрэглэх болсон билээ. Жишээлбэл,

жү. 特秀 jangiyun (жанжин)	< хят. 將軍 jiangjun
жү. 王 gun (гүн)	< хят. 公 gong
жү. 侯 hau (хэү)	< хят. 候 hou
жү. 伯 bai (бэ)	< хят. 伯 bak <sup>37</sup> гэх мэт үгс олон буй.
Мөн 胤宥莽 haganni (хааны)	< монг. qaγan-и гэсэн монгол үг ч тохиолддог.

Тэр бүхнийг үл өгүүлэн цол тушаал заасан жүрчин хэлний уугуул үгсийн талаар авч үзье. Эл талын нэр томьёоны зарим нь зөвхөн түүхийн сурвалжид тэмдэглэгдэн, зарим хэлбэр нь жүрчин бичгийн дурсгал болох “*Nǚzhēn Hua-i i-yu*” (女真華夷譯語), “*Nǚzhēn Yi Yu*” (女真譯語), “*Nǚzhēn Guan Za Zi*” (女真館雜字), “*Nǚzhēn kuan i-yu*” (女真館譯語), “*Nǚzhēn Guan Lai Wen*” (女真館來文) зэрэг хэл бичгийн дурсгалд бичигдэн үлджээ.

**bojin** (< **begin**). Овог аймгийн ахлагч нарыг “*боцзинь*” (“бэгин”) гэдэг байв. “*Цзинь ши*”-гийн мэдээгээр 1072 онд жүрчиний монянь аймаг хятанчуудын эсрэг босоход энэ аймгийн тэргүүн буюу боцзинь-ийг дурдсан байдаг нь ийм цол тушаалтныг тэмдэглэсэн анхдагч мэдээ бөгөөд тус сурвалжид нийт 40 гаруй боцзинь-ийг тэмдэглэсэн ажээ. Боцзинь нар тус тус бусдад үл харьяалагдах эзэд байсан ба энгийн цагт овог аймгаа ахлан ан гөрөө хийж “боцзинь” гэгдэнэ. Аян дайралдааны үед өөрийн харьяатаа удирдан тухайн нэгэн овог аймгийн холбоонд багтаж, захирсан өрх цэргийнхээ тооноос хамааран “мянган” юм уу

<sup>35</sup> Өмнөд Сүн улс 1127–1279 онд оршин тогтножээ.

<sup>36</sup> Умард Сүн улс 960–1127 онд оршин тогтножээ.

<sup>37</sup> Одоогийн дуудлага нь be (<bo <bak) буюу.

“мөүкэ” гэсэн нэмэлт цэргийн цол тушаалыг хүлээдэг байсан байна. “*bojin*”-ий уг хэлбэр дуудлага нь “*begin*” юм. В.И.Цинциус нарын Манж түнгүсийн хэлнүүдийн харьцуулсан толийн материалаас үзвэл, энэ үг түнгүс хэлтнээ хэрэглэгдсээр ирсэн байна. Үүнд,

эвенк. *бэжин* “1. ахлагч, дарга, 2. эзэн, 3. хадам эцэг (нөхрийн эцэг), хадам ах (нөхрийн ах), 4. хөзрийн ноён, 5. бар” ; *бэжин дэуи* “жигүүртний хаан буюу бүргэд”;

эвен. *бэжын* “1. ахлагч, дарга, 2. удирдагч, түрүү (хүн ба амьтаны)” ; *бэжынтэ*- “түрүү ахлагч гэж үзэх”; *бэжүс* “ахлах чадвартай”;

нег. *бэжин* “1. эзэн, 2. ахлагч” гэдэг<sup>38</sup> байна.

Жүрчин нар энэ “*begin*” (*bojin*~*bogin*~*begin*) цолыг /тушаал?!/ Алтан улс байгуулагдахаас өмнө хэрэглэж байсан ба Алтан улсын Тайцзу хаан Агуда анх хятан нарыг ялсныхаа дараа энэ цолыг хэрэглэхийг болиулжээ. Энэ үг түүхийн сурвалжид тэмдэглэгдсэн бөгөөд харин жүрчин бичгийн дурсгалуудад тохиолдохгүй байна.

*bojile* (< *bogile* < *begile*). Энэ цол *bojin* (< *begin*) хэмээх цолыг хэрэглэхээ байснаас хойш бий болсон гэдэг. Эхэндээ жүрчиний гол овогтон болох “ванъян” аймгийн тэргүүнийг ийн нэрлэж байгаад 11 дүгээр зууны дундуур төр засгийн байгууллага дахь нэгэн тушаалын нэр болсон байна. Түүнчлэн 1147 онд Алтан улсын хаан Монголын Аоло-боцзиле хэмээх ноёнттой энхийн гэрээ байгуулсан гэдэг түүхийн мэдээнээс үзвэл, жүрчин нар монгол, татар, онгуд болон бусад хөрш зэргэлдээ аймгийн ноён, тэргүүн нарыг өөрийн улсад үйлчлүүлэх зорилгоор энэ цолыг өгч байсан бололтой. Жүрчин нар угтаа овог аймгийн ахлагчаа хурал хурж сонгодог байснаа хожим үе улиран залгамжлах болсон байна.

“*Маньчжоу юаньлю као*”(滿洲源流考)<sup>39</sup> хэмээх зохиолд энэ үгийг гол, ерөнхий гэсэн утгат манж үг гэсэн бол “*Цзинь ши гоюй цзе*” хэмээх сурвалжид солоон хэлний үг гэж тэмдэглэжээ<sup>40</sup>. Энэ үгийн гарал нь дээр дурдсан “*begin*”- тэй холбогдох нь гарцаагүй бөгөөд *begin-le*>*begile* хэмээн бүтээврийн зааг дахь -n дэвсгэр гийгүүлэгч нь сугаран үүссэн хэлбэр болно. Жүрчин бичгийн дурсгалуудад жү. 貝戛 (*bei le*) гэсэн бичгийн түшмэлийн тушаалыг тэмдэглэсэн байдаг. Үүнийг хоёр эгшигийн хоорондох хамжих “g” гийгүүлэгч сулран шүргэх “y” гийгүүлэгч болдог Алтай хэлний авиазүйн түгээмэл үзэгдлийн дагуу *begile* > *beyile* > *beile* болсон гэж үзэх нь зүйтэй. Энэ нь жүрчин-манж хэлнээ 11 дүгээр зууны үед “-egi-” байсан авианы нийлц 14 дүгээр зуун болоход “ei” хос эгшиг болон хувирсныг нотолж буй түүхэн авианзүйн баримт юм. Түрэг хэлтэнд бас “*bey*” хэлбэртэй болсон байдаг.

М.В.Воробьев, В.В.Бартольд, Г.И.Рамстедт, Б.Я.Владимирцов зэрэг эрдэмтэн жүрчиний *begin*, *begile*, *beile*, манж хэлний *beile* (貝勒), монголын *beki*, түрэгийн *beg* (эзэн, ноён), *begi* (баатар) зэрэг үгийг гарлын хувьд холбож үзсэн нь зүйтэй юм. Харин Сэцэнцогт нарын <<Монгол үгсийн

<sup>38</sup> Сравнительный словарь тунгусо-маньчжурских языков. Материалы к этимологическому словарю. Ответственный редактор В.И.Цинциус, Т 1 (А-Н), Ленинград 1975, 672с; Т2 (О-Э) Ленинград 1977, 979с. /тус номын тэргүүн дэвтрийн 119 дүгээр талд үзнэ үү./

<sup>39</sup> Агуй (阿桂), Ю Миньчжун (于敏中) нарын зохиосон “Манжийн гарал үүслийн тухай шинжилгээ” хэмээх 18 дугаар зууны үеийн зохиол.

<sup>40</sup> М.В.Воробьев. Чжурчжэни и государство Цзинь (X в.-1234 г.). Исторический очерк. М.,1975, 448с. /Тус номын 69 дүгээр талд үзнэ үү./

язгуурын толь>>-д “бэйл” (*beyile*) гэдэг үгийг тэргүүн сайд гэх утгатай манж гаралтай үг гээд манж хэлний *beile*, *beise*, монгол хэлний *beki* зэрэг цол бол хятадын эртний ноёдын таван их цол<sup>41</sup>-ын гуравдугаар болох их авга, ахлах, ууган, тэргүүн гэсэн утгат 伯 (*bak~bo*)-тай гарал нэг бөгөөд түрэг ба манж хэлээр дамжин монгол хэлэнд зээлдсэн бололтой<sup>42</sup> гэжээ. Дээр дурдсан түнгүсийн хэлнүүд дэх “бэжин” гэдэг үгийн олон утга, үгийн хэлбэр, бүтэц, Алтай овгийн бусад хэлнүүд дэх баримт зэрэг уул үгийг эртний Алтай хэлний үг гэдэг талаас нь нотлох үндэслэл нь хятад гаралтай үг гэж үзэх үндэслэлээс илүү найдвартай байна.. Уул эртний хэлбэрийг нь \**rekin* хэмээн сэргээж болох юм. 伯-ийн солонгос дуудлага “*peg*” гэж буй нь хятад хэлний “*bak*”-ийг бодвол, эртний дуудлагыг зөв тэмдэглэсэн хэрэг юм. Үүнд, бас уугуул хятад үгийн эртний дуудлага нь “*bak*” хэмээн “*k*” дэвсгэртэй байгаа учрыг нарийвчлан нягтлууштай мэт. Б.Я.Владимирцов бээр << Ойн иргэнд ... тэдгээрийн омгийн тэргүүнд онгон тэнгэр лүгээ харилцмуй хэмээн тэдний биширэх бөө нар заримд тэргүүлэн гарч бэки хэмээх цол зүүнэ. Энэ бэки хэмээх цол басхүү говь талын нүүдэл аймгийн язгууртанд хааяа буй билээ.>> хэмээн бөөгийн шүтлэгтэнд холбогдуулан бичсэн нь, тун сонирхолтой агаад зөв чиг хандлагатай санагдана<sup>43</sup>. Магадгүй Алтайн овог хэлтэнд тооцогддог монгол, түнгүс, түрэг, солонгосын эртний өвөг дээдэс буюу умардын нүүдэлчин угсаатнаа нийтлэг асан \**rekin* гэдэг үг нэн эрт бүр Чжоу улсын үед ч нангиад хэлнээ нэвтэрсэн байхыг үгүйсгэх аргагүй. Хятадын тэр “*bak*” дуудлагатай үг хожим “*bo~be*” дуудлагатай болсон хойно жүрчин хэлэнд орсон бөгөөд монголчууд Юань улсын үед, манж нар Чин улсын үед тэрхүү 伯 цолыг хэрэглэж байв.

Анхдагч утгын хувьд дээрх цол нь Алтай хэлний бат бөх гэсэн утгат *beki~bek*, *böke* гэдэг үгстэй гарал нэг байж болох юм. Сэцэнцогт авгай монгол хэлний *böke* гэдэг үгийн тухай дурдахдаа: << хууч. аймгийн ахлагч, Монголын овгийн байгууллын үед хүч тэнхээ шалгарсан хүнээр аймгийнхаа түрүү тавьдаг байсан тул ингэж нэрлэжээ. Монгол, хамниганчууд эзнээ ‘*тир*’ буюу ‘*тйк*’ гэж, хятан, шивэй ба манжийн дээдэс жүрчин нар ч үүгээр цоллодог... Хятанаар бас ‘*bukui~buk*’ гэнэ.>><sup>44</sup> гэж бичсэн нь нэлээд ортой юм.

Мо. *beki* (бэх), *böke* (бөх), тү. *begi~beki* (баатар, эр нөхөр), *bek* (бөх, бат, бэх), якут., эвенк. *буку~буу* (хүчтэй), солоон. *буху* (бөх /барилддаг хүн) гэсэн үгс нэг гаралтай нь хэнд ч илэрхий. Жүрчиний “*begin*”, “*begile*” гэдэг үгсийн гарлыг ийнхүү тайлбарлах нь зүйтэй гэж үзсэнээсээ хойно, миний бие Ширатори Куракичи гуайн “Өвөг Түнгүс хэлний *bökin*, *bökile* хэмээх үгийн гарлын тухай” гэдэг илтгэлийг олж үзэв. Ширатори гуай мөн жүрчиний “*begin*”, “*begile*”, манжийн “бэйл”, “бэйс” зэргийг бөх бат гэсэн утгат “*beki*”-тэй холбон тайлбарлажээ. Тэр бээр *beki* → *beki+le-* гэсэн бат бөх уяж боох гэсэн үйл үг үүссэн. Манж монгол хэлнүүдэд нэр үг, тэмдэг нэрэнд –*le* дагавар залгаж үйл үг үүсгэдэг, тэр нь бас нэр үг болох тохиолдол байдаг хэмээн тайлбарлажээ.

Түнгүсийн хэлний *бэжин* ба хятадын 伯 –гийн илтгэх олон утгаас үзвэл, эдгээрийн аль аль нь овгийн байгууллын үеийн нэр томьёо аж. Эртний нийгмийн үндсэн нэгж бол овог. Овгийн

<sup>41</sup> Хятадын эртний ноёдын таван их цол гэдэг нь Чжоу (周朝 ХТӨ. 1122-249 он) улсын үеийн гүн (公), хоу (侯), бэ (伯), цзы (子), нань (男) эдгээр болой.

<sup>42</sup> Mongyol üges-ün ijayur-un toli. öbür mongyol-un arad-un keblel-ün qoriy-a. 1988, 2972pp., see 692p, 699p.

<sup>43</sup> Б.Я.Владимирцов. Чингис хаан. Шинэ толь. 1935. №1. 12-13 дугаар талд.

<sup>44</sup> Mongyol üges-ün ijayur-un toli. öbür mongyol-un arad-un keblel-ün qoriy-a. 1988, 2972pp., see 697-698 p.

ахлагчийг сонгуулиар сонгоно. Чингэхдээ, баатар чийраг, зарга тэмцлийг шийдвэрлэж чадах “бэх” хүн байх нь сонгох гол нөхцөл болно. Харь овгоос ураглах заншил тогтож, харилцан ураг бололцдог олон овог нийлэн нэгэн аймгийг бүрэлдүүлдэг байв. Энэ тохиолдолд \*rekin гэдэг үгийн утга “ бэх, бат, бөх” > ахлагч, түрүү, эзэн > хадам эцэг, хадам ах хэмээн хувирсан хэрэг болно.

Цаашилбал, эгшгийн сэлгэцээр шинэ үг бүтээдэг Алтай хэлний өвөрмөц онцлогийн дагуу дээрх үгсийн “be-, bǔ-, bǒ-” язгуурын өөр нэгэн хувилбар нь “ba-” язгуур бөгөөд энэ язгуураас мо. *batu* (бат), *bayatur* (баатар), *bayan* (баян), *baq-a* (бах) зэрэг үг үүссэн гэж үзэлтэй. Монгол хэлний “*bayan*”, түрэгийн “*bai*”, түнгүсийн хэлнүүдийн “*bajan*” гэдэг үгсийн эртний анхдагч утга нь хүчтэй, бахтай гэсэн утга бөгөөд элбэг дэлбэг, бийлэг гэсэн утга бол мөн л их эртний боловч үнэндээ хоёрдогч утга гэж бодож байна. Үгийн үндсийн хувьд *bay-a* > *bay-a* хэмээн хувьсчээ. Тэгээд ч овгийн байгууллын үед хэн хүчтэй, ид хавтай нь хөрөнгө чинээтэй байж, тэр хэмжээгээр эрх дархтай байх нь жам ёсны зүйл билээ. Урмас орж, бахдахыг заасан “*bayar*” (баяр), “*bayas-*” (баяс-) зэрэг үг мөн нэг гаралтай биз ээ. Эртний түрэгийн мэргэн Тоньюкук “*bojla bayar tarqan*” хэмээх цолтой байсны эхний хоёр үг мөн л энэ язгуураас гаралтай үгс бөгөөд Алтай овгийн хэлтнээс орос хэлнээ орсон “баяр, боярин”, “богатырь, богатый” хэмээх үгсийг харьцуулан үзэж болох юм. Монгол, түрэгийн адил жүрчин, манж нарын дотор ч “*baturu*”, “*bayan*” цолтон цөөнгүй байсан нь лавтай бөгөөд цөм Алтайн овог хэлний дундын үгс болно. Мөн Аварын хаант улс<sup>45</sup>-ын анхны хаан Баян (*Bayan*)<sup>46</sup> нэртэй байжээ. Тэр бол 6 дугаар зууны үед нирунчууд “*bayan*” гэдэг үгийг хүний нэр, цаашлаад цолонд идэвхтэй хэрэглэж байсны нотолгоо гэж үзэлтэй.

***hulu***. Хэд хэдэн аймгийн захирагч нарыг бас “хулу” гэж байв. Энэ нь ерөнхийлөн захирагчийг хэлсэн үг бөгөөд “бэжилэ”-г бодвол илүү хүчирхэг ахлагч нарыг тавьдаг байжээ. Жүрчиний эдгээр түрүү ноёдыг овог аймгийн хурлаас сонгон тавьдаг байсан аж. В.П.Васильев жүрчиний “*хулу боцзиле*” гэдгийг манжийн “*үхэри бэйлэ*” буюу бүгдийн бэйл гэдэгтэй дүйцүүлэн үзсэн нь бүгд ерөнхийлөн захирах үүргийг нь харгалзсан хэрэг бололтой. “*hulu*” хэмээх үгийн гарал тун бүрхэг. Хэдийгээр баттай үндэслэл үгүй боловч нэгд, манж хэлний *gubči* “бүгд, хамаг, хотол, даяар”, *gurun* “улс”, *gulhun* “бүхэл”; монгол бичгийн хэлний *gür, kür* “гүр~хүр /бүгд, хамаг гэсэн утгат”, *küm~kóm* “цөм” зэрэг үгтэй гарал нэг байж болох талтай; хоёрт, энэ нь цаашлаад “*huri*” гэсэн Монголын Нууц Товчоонд тохиолддог цолын нэртэй ч эртний төрөл үг /өөрөөр хэлбэл, олон хэл аялгуунд *gǔ-, kǔ-, hǔ-, hu-* гэсэн хувилбар бүхий нэг язгуураас үүсэлтэй/ байж болох юм гэсэн таамаг дэвшүүлж болохоор байна.

***dubojile*** (都勃極烈) < (*dubegile*) Жүрчин овог аймгууд нэгдэн эрх баригч нараа сонгодог байснаа больж, үе улиран залгах болсон үед энэ цол бий болжээ. Их бэжилэ гэсэн утгатай. “*Алтан улсын судар*”-т дурдсанаар ах Уяшу-г нь нас барсны дараа Агуда-д анх ‘*dubojile*’ цол өргөмжилж байсан бөгөөд тэр үед түүнээс эрх нөлөө багатай ‘*bojile*’ цолтон цөөн бус байжээ. Миний

<sup>45</sup> Одоогийн Унгар, Словак, Хорват, Румыний нутагт 562-823 оны хооронд тогтнож байв.

<sup>46</sup> Аварын хаант улсыг үндэслэгч тэр бээр 562-602 онд төр барьжээ.



санахад, “du”<sup>47</sup> нь зарим эрдэмтний дурдсанчлан хятад хэлний “их” гэсэн утгат “ta(i)~da(i)” юм уу, эсвэл манж, солоон хэлний “уг, язгуур, үндэс, тэргүүн, дарга” гэсэн утгат “da” гэдэг үг биш, харин “дээр, дээд” гэсэн утгат “de” хэмээх жүрчин /манж/ үг гэж бодож байна.

**mingan** (猛安). Жүрчин нар Төв Азийн бусад нүүдэлчдийн нэгэн адил эрт Хүннүгийн үеэс уламжилсан цэрэг-засаг захиргааны аравтын системийг хэрэгжүүлж байв. “mingan” хэмээх нь мянгат хийгээд мянгатын ноёныг заасан үг болно. Тус тооны нэр нийт Алтай овгийн хэлний нийтлэг үг буюу. Хожим хятадын төв ба хойд хэсгийг эзлэн захирах болсон үедээ жүрчин нар мянгатын ноёныг заах “qianhu (千戶)” гэдэг нангиад үгийг хэрэглэдэг болжээ.

**mouke** (謀克). Аравтын систем дэх “зуут” ба “зуутын ноён” –той дүйнэ. Энэ үгийг судлаачид манж хэлний “muke” буюу ус гэдэг үгтэй холбож үздэг нь зүйтэй мэт. Тус тусдаа ахлагч бүхий жүрчиний овог аймгууд нь хэрэгцээ тохиолдвол, овог аймгийн холбоонд нэгдэн мянгат цэргийг бүрэлдүүлж байсан бөгөөд өрхийн их багаас хамаараад 50 юм уу 100 цэрэг гаргаж байжээ. Жүрчин овгууд тус тус нэгэн гол ус дагасан нутагтай, тэндээс цуглах нэг овгийн цэрэг нь нэгэн нэгж болдог байснаас ийнхүү “mouke” гэж нэрийдсэн биз ээ. Манж хэлний “muke”(ус), түнгүсийн хэлнүүд дэх “мү:”, “мө:”, “мүэ”(ус), монг. “mögen”(мөрөн), солонгос хэлний “mul”(ус) зэрэг үг гарал нэгтэй байна. Хожим энэ үг мартагдан зуутын ноёныг заасан “bohu~baihu (百戶)” гэдэг үгийг хэрэглэх болжээ. В.И.Цинциус нарын харьцуулсан тольд бичигт манж хэлний “мэокэ” гэдэг нь 1. гурван зуун хүнээс бүрдсэн бүлэг, 2. гурван зуун өрх бүхий гацаа сууринг заасан утгатай гэжээ. Энэ нь “Алтаны цэргийг зохиосон нь, гурван зуун өрхийг мэхэ, арван мэхэ нэг мэн /мянган, М.Б./ хэмээжээ” гэсэн Алтан улсын сударын мэдээнээс эхтэй тайлбар болов уу.

Монголын Нууц Товчоонд гардаг *ca'ut-quri / ja'ut-quri* хэмээх нэрийн талаар олон судлаач шинжилсэн бөгөөд хамгийн сүүлд профессор Ц.Шагдарсүрэн тусгай өгүүлэл бичиж нийтлүүлсэн<sup>48</sup> байна. Тэр бээр монгол хэлний “caur- >ca'ur-”, жүрчин хэлний “[жү. 𐰃𐰆] \*cau-ha”, манж хэлний “choha” зэрэг үгтэй холбон үзээд << ...*Ja'ud-quri ~ Ca'ud-quri* гэдэг цол нь Өвөг Алтай хэлний уугуул үг бөгөөд түүнээс монгол, зөрчид, манж хэлнээ зэргэцэн салбарлаж, өөр өөрийнхөө жам хуулиар хөгжихдөө аль алинд нь шилжисэн утга буй болсон, тэгээд ч зөрчид хэлнээ хийсвэр утгатай болсон *Ja'ud-quri ~ Ca'u-quri* гэдэг хэлбэр нь цэрэгийн гавъяа зүтгэлтэнийг хөхиүлэн шагнаж олгодог цол нэр болсон гэж үзэх үндэс таамаглал гарч байна.>> хэмээн дүгнэжээ. Үүнтэй холбогдуулж хэлэхэд, судлаачид мөн Монголын Нууц Товчоонд гардаг ‘*Ala-qus digit-quri*’ гэдэг нэрийг анхаарч үзэх хэрэгтэй юм. Түрэг хэлтэн байсан гэгдэх Онгуд аймгийн эзний нэр Алахуш, харин “*digitхүри*” гэдэг нь цол гэж үзэх нь зүйтэй бөгөөд энэ цолыг мөн Алтан улсаас өгсөн байж таармаар. *digit-quri*-ийн *digit*-ийн тухайд, түрэгүүдийн их төлөв “*tarkhan*” гэж дууддаг цолыг монголчууд “*darqan*” гэж дууддагтай адил, түрэгийн *tekin~tikin~tigin*-ий олон тоог МНТ-г авиалан галиглагч “*Digit*” гэсэн байж магадгүй.

<sup>47</sup> Хятадаар бүгд, цөм гэсэн утгат ханз бичжээ. Нэгэнтээ утгыг яв цав харгалдуулж чадах дуудлага ойр ханз үгүй тул, хэд хэдэн овог аймгийг нийдэм нэгтгэн захирдаг онцлогт эрхбиш дөхүү утгат хэмээн тийнхүү “бүгд” гэдэг “*dou* (都)” ханз тавьсан биз ээ.

<sup>48</sup> Ц.Шагдарсүрэн, “*Ja'ud-quri ~ Ca'ud-quri* хэмээх цолын учир холбогдолд нэмэрлэх санал”, Солонгосын балар эртний соёл, гарал үүслийн асуудал. Хэлний судалгаа., 3-16т, Улаанбаатар 2008

Тэгж үзвэл, “digit-quri” нь тигин бүгдийн тэргүүн гэсэн шиг утгатай цол болно. Түүнчлэн МНТ-ны §177-д Qulbari-quri хэмээх Хэрэйд аймгийн хүн дурдагддаг. Энэ нэр бүтнээр юм уу, үгүйдээ эцсийн “-quri” нь лавтай цол гэдэгт эргэлзэхгүй байна. Дашрамд өгүүлэхэд, “Дайляо улсын судар”-т “tama rung sali” хэмээх хятан үгийг хүн дагах сайн эзэн, “ajusali” гэдгийг эцэг өвгөдийн мэт сайн эзэн гэсэн үг хэмээн тус тус тайлбарласан буй. Чингэхээр “sali” гэдэг нь сайн эзэн гэсэн үг аж. Монгол хэлний “\*sayin > sayin > sayin”, орчин цагийн түрэг хэлний “say”-ийн язгуур нь “sa-” бөгөөд энэ нь тус хятан үгийн “sa-”-тай тохирно. Харин “-li” (магадгүй угтаа “-li” дуудлагатай байсан ч болов уу) төгсгөл ба “-quri”-ийн -ri хэлний нэг махбод байж болзошгүй. Манж бичигт баатарыг “baturu~baturi” хэмээн 2 янз бичсэн үзэгддэг. Жү. ма. baturu~baturi, жү.nekuru, мо.б.х. bayatur, nöküг зэрэг үгийн төгсгөлийн -r, -ri, -ru төгсгөл бас холбогдож болохыг анхаарууштай.

1113 онд Агуда бээр бэсигле-гийн түшмэлийн дүрмийг бий болгосноор түшмэлийн 10 зэрэг тогтсон байна. Гэвч тэр арван зэрэгт орох нэрс, дэс дарааг сурвалж бичгүүдэд зөрүүтэй тэмдэглэсэн байдаг. В.П.Васильев X-XIII зууны үеийн Төв Азийн түүхийг судалж, хятан, жүрчид, монголын түүхэнд холбогдох нангиад сурвалжийн мэдээг хавсаргасан нэгэн зохиолдоо тэдгээр түшмэлийн 10 зэргийг манж дуудлагын хамт оруулжээ<sup>49</sup>. Үүнийг монгол орчуулгын хамт жагсаавал,

1. дубоциле / 都勃極烈/	(да бэйлэ)	- да бэйл /дээд бэйл?/
2. аньбань боциле / 諳版勃極烈/	(амбань бэйлэ)	- их бэйл
3. голунь хулу боциле	(гүрүнь үхэри бэйлэ)	- улсын бүгд бэйл
4. голунь боциле	(гүрүнь бэйлэ)	- улсын бэйл
5. иши боциле	(йенши бэйлэ)	- енши? бэйл
6. илай боциле	(илаци бэйлэ)	- гутгаар бэйл
7. амай боциле	(аймань бэйлэ)	- аймгийн бэйл
8. ашэ боциле	(асхань бэйлэ)	- дэд /жигүүрийн/ бэйл
9. у боциле	(вэнь бэйлэ)	- вэнь? бэйл
10. дэ боциле	(дэту бэйлэ)	-дэту ? бэйл

Японы И.Ивакити, Я.Жиньичи зэрэг судлаачийн гаргаснаар<sup>50</sup> :

1. дубоциле	- ерөнхий удирдагч /буюу ноён, бэйл/
2. аньбань боциле	- их ноён
3. голунь хулу боциле	- шударга жолоодогч ноён
4. голунь цзо боциле	- зүүн шударга ноён
5. голунь иши боциле	- баруун шударга ноён
6. голунь амай боциле	- тэргүүн шударга ноён
7. голунь цзэ боциле	- дэд шударга ноён
8. голунь илай боциле	- гутгаар шударга ноён
9. голунь де боциле	- дөтгөөр шударга ноён
10. ашэ боциле	- бага ноён

<sup>49</sup> Васильев В.П. История и древности восточной части Средней Азии от X до XIII в. с приложением китайских известий о киданях, джуржитах и монголо-татарах, -ТВОРАО, ч.IV, вып.1. 1859, 118-119с.

<sup>50</sup> Эдгээр 2 янзын жагсаалтыг <М.В.Воробьев. Чжурчжэни и государство Цзинь (X в.-1234 г.). Исторический очерк. М.,1975, 448с.> хэмээх номын 169 дүгээр талаас авч оруулав.

Эдгээр цол зэрэгтнийг цөм хааны ойр шадрын ванъян овогтноос тавьж байв. Гэхдээ энэ 10 зүйл цол хэргэмтэн нэг цаг үед нэг дор бий болчихоогүй, урьд хожид гарсан байна.

Алтан улсын түүхэнд холбогдох тэмдэглэл хийгээд жүрчин үсгийн дурсгал дахь цол хэргэмийн зүйлийг ажиглахад, үнэхээр бүгд Алтан улсын үед хэрэглэж байсан нэр үү, эсвэл зарим нь түүнээс хожуу хэрэглэх болсон нэр үү гэдгийг ялган салгаж үзүүштэй ажээ. Жүрчин хэмээх нэрийдэл нь манж нар хүчирхэгжин төр улсаа байгуулсан цаг үе хүртэл хэрэглэгдсээр байсан бөгөөд Орос ба өрнөдийн судлаачид мөн тэр дагуу бичсээр иржээ. Ингэж үзвэл, Их Юань (大元帝国) улсын үеэс аваад Хойд Алтан улс (後金)<sup>51</sup>-ын эцэс үе хүртэлх цаг хугацаанд жүрчин нар монгол хүний нэр, монгол цол хэргэм, албан тушаалын нэрийг авч хэрэглэх явдал түгээмэл байв. Тухайлбал, 15 дугаар зууны үед Хададай, Бату буха, Даругачи, Лан Баргудай зэрэг монгол нэртэй жүрчин аймгийн түрүү ноёдын нэр түүхэнд тохиолддог. Энэ нь тэр үед жүрчиний дотоод болон гадаадад монголын нөлөө үлэмжхэн байсантай шууд холбоотой юм.

Хураангуйлан товч дүгнэхэд, Жүрчиний цол хэргэм, албан тушаалын нэрийн зүйлд өөрийн хэлний нь үг харь үгийг бодвол харьцангуй цөөн, зарим нь хэсэг зуур хэрэглэгдэж байгаад орхигдсон байна. Мөн утга гарал нь тодорхой бус жүрчин цол хэргэмийн зүйл ч бий. Харин Хятад, Солонгос, Хятан нар жүрчиний овог аймгийн ахлагч нарт их төлөв хятад гаралтай цол хэргэмийн нэр өгч байсан ба Алтан улс төрийнхөө зохион байгуулалтад урьд урьдын династийн уламжлалаас үлгэр туршлага авч байсан шалтгааны улмаас мөн үлэмжхэн хятад гаралтай үгийг хэрэглэж байжээ. Зөвхөн жүрчин нар ч бус бас монголчуудын хэрэглэж байсан цол тушаалын нэрийг аваад үзэхэд нангиад гаралтай үг цөөнгүй, зарим нь нэлээд монголжуу маягтай болсон байдаг. Тухайлбал, ноён (<老爷), ван (<王), гүн (<公)<sup>52</sup>, үйзэн (<卫掌), шүүлэнгэ, зайсан (<宰相), жонон (<管主), тайш (<太师), тайж (<太子), хунтайж (<皇太子), тавнан (<tabun主), бэйж (妃子), шигүши (<指挥使), гүен (<姑爷), дайюу (<太尉), хонжин (<官人), тайху (<太后), нагнан тайху, буйма (<驸马), тойн (<道人) гэх мэт хятад гаралтай олон нэрийг дурдаж болох юм. Энд юуны өмнө хоёр гол шалтгаан байна гэж бодож байна. Нэгд, хятадууд их төлөв зах хязгаар нутгаа хамгаалж илбэн аргадах, өөртөө татах гэж хятадын уламжлалт цол тушаалыг нүүдэлчдийн эрхтэн дархтанд өргөж байсан, хоёрт, Сяньбигийн олон салбар аймаг улс, хятан, жүрчин, монгол, манж нар ээлж дараагаар хятадыг бүхэлд нь буюу хэсэгчлэн эзэрхэхдээ засаж захирахад хялбар оновчтойг харгалзан хятадын уламжлалыг харгалзсан учир тийнхүү нангиад нэр цолыг үлэмжхэн хэрэглэж байжээ. Юань улсын үе болон түүнээс хойшлох тусам жүрчин нарын дунд монгол гаралтай цол хэргэм, албан тушаалын нэр хэрэглэх явдал түгээмэл болж ирсэн байна.

## 2. Манжийн цол хэргэмийн зүйл

Манж хэмээх нэрийг улс төрийн учир шалтгаанаар гаргаж ирснээс бус жүрчин манж хоёр нь нэг угсаатан, нэг хэлтэн юм. Дайчин улсын Тайцзун хунтайж бээр жүрчин гэдэг нэрийг халж, үндэстнээ манж гэх болсон тухай << Манай улсын нэр уул нь манж (滿州), хада, ула, ехэ, хойфа гэх зэргээр байв. Үүнийг үл мэдэгчид ер нь жүрчин гэсээр буй. Жүрчин хэмээгч шивэийгийн Чуу мэргэний угсаатан болой. Тэр нь мантай ямар хамаатай буй. Үүнээс хойш

<sup>51</sup> Хойд Алтан улс гэдэг нь “хожуугийн, хойч” гэсэн утгат нэрийдэл бөгөөд Умард Алтан улс гэсэн мэтээр ойлгож болохгүй. 1616- 1636 онд хамаарна. 1636 онд Абахай хаан улсынхаа нэрийг Чин улс гэж халжээ.

<sup>52</sup> Гүн гэдэг хэргэмийг манж хэлний гавьяа гэсэн утгатай “gung” хэмээх үгтэй холбон үзсэн тайлбар байдаг ч, үнэндээ эртний Чжоу улсын үеийн таан зэрэг цолын эхнийх нь бөгөөд хожмын Хятадын нутгийг эзлэн суусан олон төр улсад уламжилсаар иржээ.

цөм манай улсынхаа уулын манж гэх нэрээр дуудах хэрэгтэй. Дахиад жүрчин хэмээгч буй болбоос ялдамуй.>><sup>53</sup> хэмээн зарлиг болж байжээ. Ийнхүү 17 дугаар зууны эхнээс манж гэх болсон боловч бид Нурхачи жүрчин аймгуудыг нэгтгэн хүчирхэгжиж байсан, Хойд Алтан улсын өмнөхөн үеийн цол хэргэмийн зүйлээс эхлэн авч үзэх нь зүйтэй юм.

Манж буюу жүрчин нар өөрийн үндэстний урьдын төрийн нэрийг авч улсаа Хойд Алтан улс хэмээн ялган нэрлэж байсан цаг үе бол монголчуудын соёлын нөлөө хамгийн их байсан цаг үе билээ. Гарлын хувьд нэг бөгөөд харьцангуй эрт цагаас хэрэглэж байсан мо.\*šaurha ~ ма.šooha, жү.nekuru ~ ма.neku “найз” ~ мо.nōkūr<sup>54</sup> гэх мэт үг байна.

Энэ үед манж нар монгол цол хэргэмийн зүйлийг эрхэмд үзэж байсныг нотлох баримт их бий. Заримаас нь дурдвал, < Нурхачи өөрийн дүү нар болох Шургачи-д “darhan baturu”, Баяара-д “joriytu”, Мургачи-д “cing baturu” хэмээх цол, хөвгүүддээ “hūng baturu”, “arγatu tumen”, “guyeng baturu”, “mergen baturu”, “erke cōgekur” зэрэг цол шагнаж байсан ба Нурхачийг өөрийг нь манж монгол хэлээрхи албан бичгийн зүйлд ямагт өвөр халхын Энгэдэр тайжийн өргөснөөр “Sure Kundulen han” (Сэцэн Хүндлэн хаан) хэмээн бичдэг байжээ. Энэ “kūndūlen” гэдэг нь Умард Юань улсын үед “Байсахал хүндлэн хаан”, “Энхэбэй хүндлэн хааша”, “Нахиа хүндлэн чөөхүр”, “Халигучины удаач хүндлэн”, “Убаши хүндлэн чөөхүр” гэх мэтээр идэвхтэй хэрэглэж асан монгол цол бөгөөд “хүнд их” гэсэн утгатай гэж үзэх нь зүйтэй байна. Манжийн хааны шадар зөвлөх бөгөөд бичгийн их түшмэлд “баги” цол өгч байв. Мөн “заргач” хэмээх тушаалтныг томилдог байжээ><sup>55</sup>.

Нурхачи баатар 1601 онд цэргийн тугийн өнгөөр ялгасан 4 хошуу байгуулжээ. хошуу нь сумаас бүрдэнэ. Сум бүр 300 хүнээс бүрдэх бөгөөд түрүүг нь “nirui ejen” (сумын эзэн) гэнэ. 1614 онд нэмж 4 хошуу байгуулснаар манж найман хошуу бий болов. Сум нь дотроо зуут, аравтад хуваагдана. 5 сум нийлж нэг “jalan”(залан), 5 залан нийлж нэг “γūsa” (хошуу) болдог. Хошууны дотор бас зүүн баруун гар зохион түүнийгээ “meigen” гэж байв. Эдгээрийн захирагчидыг “jalan-i ejen”, “γūsai ejen”, “meigen-i ejen” гэдэг. Эдгээр нь манжийн цэрэг-засаг захиргаанд анх бий болгосон тушаалын нэрс юм. Хожим монголчууд залан, мэйрэн зэргийг нэгж заасан утгаас нь гадна захирах албан тушаалынх нь утгаар давхар хэрэглэх болсон билээ. “jalan” гэдэг нь манж хэлний “γe”, “meigen” гэдэг нь “mөр” гэсэн утгат үг болно.

Тайцзун хаан улсаа Чин улс хэмээн халаад түшмэдийн цол тушаал, хэргэм зэргийг шинэчлэн тогтоожээ. Тухайлбал, “han-i araha daičing gurun-i uheri qooli”-д:

1.101. zung žin fu yamun i qooli. <<yaya hergen fungnerengge wesihun erdemungge i sučungγa aniya toytobuhangge, iletulehe mafa i juse omosi-be gung erdemu-be bodome hergen-be uyun jergi banjibufi, uju jergingge-be hošoi čing wang obuha. jai jergingge-be doroi giyung wang obuha. ilači jergingge-be doroi beile obuha. duiči jergingge-be γūsai beise obuha. sunjači jergingge-be gurun-be dalire gung obuha. ningguči jergingge-be gurun-de aisilara gung obuha. nadači jergingge-be gurun-be dalire janggin obuha. jaqūči jergingge-be gurun-de aisilara janggin obuha. uyuči jergingge-be

<sup>53</sup> Jin Gang. *Jūrčin ūndūsūten-ū neres-ūn udq-a yarul-i sinjilekū ni* : Mongγol kele udq-a jokiyal. 2004, №5, 48-57р. /Тус цувралын 56 дугаар талд үзнэ үү./

<sup>54</sup> Монгол хэлний nōkūr гэдэг үгийн эртний хэлбэр \*nekūr байснаа 14 дүгээр зууны үед тэргүүн үеийн эгшиг нь уруулаар ухран ижилссэн болов уу.

<sup>55</sup> М.Баярсайхан, *Монгол манж албан бичгийн харьцаа*. : Acta Mongolica 2007, vol.7(291), ISBN 99929-5-572-4, 157 дугаар талд.

gurun-be tuwakiyara janggin obuha. tereci yüwa-be gemu uysun obuha. >>

Орчуулбал, “Хааны бичсэн Дайчин улсын бүгд хууль”-д:

1.101. Цзун цзинь фу яамны хууль. <<Аливаа хэргэм өргөмжлөх нь Дээд эрдэмтийн анхдугаар онд (1636) тогтоосон нь, Илэрхийлсэн өвөг<sup>56</sup>-ийн хүүхэд ач нарыг гавьяа эрдмийг бодон хэргэмийг есөн зэрэг байгуулж,

тэргүүн зэргийг нь *хошой чин ван* болгов.  
 дэд зэргийг нь *төрийн жүн ван* болгов  
 гутгаар зэргийг нь *төрийн бэйл* болгов  
 дөтгөөр зэргийг нь *хошууны бэйс* болгов  
 тавдугаар зэргийг нь *улсын түшээ гүн* болгов  
 зургаадугаар зэргийг нь *улсад туслагч гүн* болгов  
 долдугаар зэргийг нь *улсын түшээ занги* болгов  
 наймдугаар зэргийг нь *улсад туслагч занги* болгов  
 есдүгээр зэргийг нь *улсад сахигч занги* болгов  
 Түүнээс бусдыг цөм угсаа болгов.>> гэжээ.

Эдгээр нь зөвхөн “*aisin gioro*” овогтны хэргэм зэрэг юм. Үүнчлэн мөн хатад, гүнж авхай нарын хэргэм зэрэг, угсааныханд олгох хэргэм зэрэг, дотоод ба гадаад засаг хошуудын ноёдод олгох гээд цөм ялгавартай, хуулиар тогтоосон байдаг. Жишээлбэл, “*adaha hafan*” (монголоор “дэсэлсэн түшмэл”) гэхэд л Манжийн хаанаас тусгайлан цэргийн гавьяа байгуулсан хүмүүст олгодог 6 зэрэг цол юм.

Энэхүү 6 зэрэг цол нь:

- *jinkini hafan* /жинхэнэ түшмэл буюу чухам түшмэл, тэргүүн, дэд, гутгаар/
- *ashan i hafan* /жигүүрийн түшмэл буюу дэд түшмэл, тэргүүн, дэд зэрэгтэй/
- *adaha hafan* /дэсэлсэн түшмэл, тэргүүн, дэд, гутгаар зэрэгтэй/
- *tuwasara hafan* /горьт түшмэл/
- *tuwakiyara hafan* /сахигч түшмэл/
- *baitalabure hafan* /хэрэглэгдэх түшмэл/ эдгээр болно.

Энэхүү 6 цолыг Гадаад ван гүн нарт бус зөвхөн манж найман хошууны манж, монгол ноёд, тайж нарт олгоно. Тиймээс найман хошууны бүрэлдэхүүнд орсон Монголын Түмэд, Цахарын ноёд эдгээр цолоор шагнагдаж байжээ. Холбоо үгээр бүтсэн энэ мэт нэр томъёог их төлөв хуулбар орчуулгаар монголчилсон харагддаг.

Манж нар Мин (明)<sup>57</sup> улсыг мөхөөн 1644 оноос Бээжинд нийсэллэж, хятадыг захирах болсон үеэс хятадын олон муж, төвийг захирахдаа хятад иргэнийг эрхшээхэд тохиромжтой төрийн байгууламж байгуулан, монголыг захирахад мөн монголд тохиромжтой хувилбарыг бий болгожээ. Ер үндэстэн үндэстнийх нь уламжлалыг харгалзан үзэж байсан тул үүнийг дагалдаад манж хэлний нэр цолоос гадна хуучин байсан хийгээд шинээр бий болгосон хятад, монгол, төвд, уйгур цол хэргэмийн зүйлийг тухай тухайн газар орон, холбогдох яам жургаанд хэрэглэж байв. Мөн бодлого хэрэгжүүлэх үүднээс зарим цол хэрэглэх явдлыг хааны зарлигаар халах буюу хорьж байсан юм. Тухайлбал, 1691 онд Долон нуурын чуулган болох үест Халхын

<sup>56</sup> Илэрхийлсэн өвөг гэдэг нь Нурхачийн эцгийн хойно өргөмжилсөн цол бөгөөд уг нэр нь Тагси болно.

<sup>57</sup> Мин улс 1368-1644 онд оршин тогтножээ.

Засагт ханы Пунцагравдан, Соном-Ишжав нарын үеэл ах дүү ноёд угсаа залгамжилж ирсэн жонон цолыг булаалдсаны учир, цааш тэмцэл хагарал даамжрахаас сэргийлэн Энх-Амгалан хаан жонон цолыг нь байлгаж, эхнийхийг нь засаг төрийн жүн ван, удаахийг нь засаг тэргүүн зэрэг тайж болгож байжээ<sup>58</sup>. Энэ үеэс Монголд дахин жонон цол гараагүй буюу.

Тэр бүрийг үл дурдан зарим манж цол хэргэмийн зүйлд холбогдох нэрийн учрыг авч үзье.

**cola** “Хорин нэгтийн тайлбар толь”-д эрхэмлэн дуудах нэрийг цол хэмээмүй гэжээ. Энэ үг манж, монгол хэлний дундын үг бололтой. ма. *colurogo*-(шалгарах), мон. *coila*-(цойлох) зэрэг үг нэг язгууртай байна.

**hergen** Энэ нь угтаа үсэг хэмээх манж үг юм. Гэхдээ одоогийн үсэг /letter, script/ гэсэн утга хийгээд нэр /noun/ гэсэн утгын аль алиныг илтгэнэ. Иймээс сайд түшмэлийн доторхи байр суурийг заасан албан ёсны нэр, тамга тэмдэгээс аваад бичигт тавих үсэг гэсэн утгаар зэрэг дэвийг ялгасан нэрийг “hergen” гэх болсон бололтой. “hergen” нь манж хэлний “hese”(зарлиг), монгол хэлний “kele (хэл)” зэрэг үгтэй гарал нэг юм. Манжийн үед бүх хэргэм дотроос иххэнд тооцогдох ван, бэйл, бэйс, гүн дөрвийг хэтэрхий дөрвөн хэргэм гэдэг байв.

**jergi** Түшмэлийн дэвийг зэрэг гэнэ. Манж монгол хэлний дундын үг болно.

**hafan** Чингийн үед жинс, бүс бүхий төрийн албан тушаалтныг hafan /түшмэл/ гэдэг байв. Жүрчин хэлэнд бас хэрэглэж байсан түшмэл гэсэн утгатай үг. В.И. Цинциус нарын Түнгүс манж хэлнүүдийн харьцуулсан тольд жү. ма. hafan “түшмэл”-ийг хят. *kuan* 官 “ноён” (эдүгээ *guan* дуудлагатай болсон)-тай холбожээ. П.П.Шмидт бас ингэж үзсэн байна. Хятад хэлний “ua” өгсөх хос эгшигтэй үгийг манж хэлэнд тэр хосгийн эгшигийг нь “afa” гэсэн авианы нийлцтэй болгон хэлэх ёсгүй. Учир нь, уугуул манж үгэнд “ua” хос эгшиг харин ч цөөн бус тохиолддог, мөн уруулын эгшигийг уруулын гийгүүлэгчээр солин хэллээ гэхэд сул дуутай “w”-аар хэлэхээс бус чанга, амьсгалын түрэлттэй “f”-аар солин хэлэх ёсгүй мэт санагдана. Харин Г.И.Рамстедт аварчуудын хэлэнд байсан “karkhan”, эртний түрэгийн қаруан гэдэг үгийг манж хэлний hafan лугаа холбогдоно гээд эдгээр нь угтаа хятад-солонгосын kappan (< кар kuan “тэргүүн түшмэл”) гэдгээс гаралтай гэж үзсэн байна. Г.И.Рамстедт гуайн санал зүйтэй бөгөөд үүсэл тархацын хувьд үнэхээр хятад, солонгос, эртний нирун буюу аваричууд, жүрчин, манж, бас аваричуудын хэл соёлын нөлөө их орсон эртний түрэг, булгар хэлэнд энэ үг тархсан байх нь тун боломжтой билээ. “Hafan” бол жүрчин хэлнээс манжид уламжилсан үг бөгөөд бараг уугуул манж үг мэт идээшсэн байжээ. Монгол хэлний qaban “хаван” –г зарим хүн “hafan”- тай холбон манж хэлнээс орсон үг гэсэн байдаг. Монголын qaban харин ч манжаас орсон бус, Юаний үед юм уу, Умард Юань улсын үед хятад хэлний *kuan* 官 –аас орсон үг байж болох юм.

**beile** (貝勒) Хэтэрхий дөрвөн хэргэмийн хоёрдугаархи. Энэ үгийн гарлын тухайд жүрчин хэлний “begile~bogile”-тэй холбон өмнө тайлбарласан билээ. Хойд Алтан улсын

<sup>58</sup> Зарлигаар зарсан Гадаад Монгол, Хотон аймгийн ван гүнгүүдийн илтгэл шастир. 62 дугаар дэвтэр, шастирын 46 дугаар; мөн зохиолын 64 дүгээр дэвтэр, шастирын 48 дугаарт буй.

өмнөхөн үед (16 дугаар зуун) жүрчиний олон аймгийн ахлагчийг 10 дугаар зууны үеийн нэгэн адил “бэйл” гэж нэрлэсээр байжээ. Нурхачи баатар ч мөн олон аймгийг нэгтгэн захирч байсан үедээ *Sure beile* “Цэцэн бэйл” гэгдэж байсан бөгөөд 1605 онд халхын баюуд аймгийн Энгэдэр тайж “*Kündülen qaγan*” цол өргөснөөс хойш бэйл гэхгүй, хаан гэх болжээ. Хэтэрхий дөрвөн хэргэмийн зэрэг дэв бий болохоос өмнө “бэйл”-ийг ноён гэсэнтэй дүйх утгаар хэрэглэж байв. Манжийн *Дусал бинтгүй үсгийн данс* буюу “*Ejehe dangse*”-д монголын “ноён”-ыг манжаар “beile”, манжийн “бэйл”-ийг монголоор “ноён” хэмээн орчуулж байсан явдал үүний гэрч юм.

***beise*** (貝子) Чин улсын хэтэрхий дөрвөн хэргэмийн дөрөвдүгээр. Монгол хошууны бэйс нь төвийн шатны төрийн бэйсээс эрх мэдлийн талаар хол бага. Жүрчин бичгийн дурсгалд жү.固土米夙朱 *gurunni begi se* гэсэн үг тохиолдож байна. Манжийн “*Ejehe dangse*” дахь 1619 оны манж халхын харилцан амалдсан үг, Энх-Амгалан хааны үеийн бичгүүд тухайлбал, Зүүнгарыг түвшитгэн тогтоосон бодлогын бичгийн 3 дугаар дэвтэр зэрэгт халхын олон бэйс гэх мэтээр бичсэн буй. Тэр цагт монголд бэйс хэргэмтэн гэж байсангүй. Эдгээр дурсгалууд дахь бэйс гэдэг үгийн утгыг нь үзвэл ноёд гэсэн утгаар хэрэглэгджээ. Үүнээс үзвэл бэйс хэмээх үг нь “бэйл” гэдэг үгийн олон тоог заасан үг байснаа хожим бэйлээс багахан өөр нэгэн хэргэмийн нэр болсон нь ямар ч эргэлзээнгүй. *Beile + se > beise* хэмээн хувирсныг тайлбарлавал, *beilese* бүтэцтэй үгийн “-le-” үеийн эгшиг тун балархай хэлэгдэхийн хамтаар дараалсан хоёр гийгүүлэгчийн аль нэг нь сугардаг Алтай овгийн хэлний нийтлэг үзэгдэл ёсоор “l” нь сугарч “beise” гэдэг хэлбэр бий болсон байна.

***janggin*** 章京 *zhāngkīng*. Монголчууд эцсийн гийгүүлэгчийг нь гээж занги хэмээн дуудна. Хошууны доторхи 150 хүнийг нэг сум болгож, *сумын занги*-аар захируулж байв. Занги нь сумын хууль цааз, гааль татвар, хуяг эрсийг данслан хянана. Энэ үгийн гарлыг хят. 掌印 *zhang yin* “*tamga bariyici*”, 章京 *zhang jing* зэрэгтэй холбон үздэг.

***amban*** Угтаа их гэсэн үг. Монгол хэлний “амбан шар” гэдгийн амбан бол даруй их гэсэн манж үг болох тухай профессор Л.Мишиг дурдсан байдаг. “*amban*” гэдэг үг их, том гэсэн утгаас гадна сайд гэсэн утгаар хэрэглэгдэж байгаад аажмаар *amba-amban* гэсэн хоёр хэлбэрийнх нь эхнийх нь “их, том”, удаах нь “сайд” гэсэн утгыг ялган заах болсон байна.

***hošoi*** Чингийн үед *hošoi čin wang* “*хошой чин ван*”, *hošoi efu* “*хошой тавнан*”, *hošoi gege* “*хошой авхай*”, *hošoi gungju* “*хошой гүнжэ*”, *hošoi fujin* “*хошой хатан*” гэх зэрэг цол байв. Энэ манж, монгол хэлний “*hošoi~хошой*”-г зарим толь бичигт бичсэнчлэн хоёр удаагийн, давхар гэсэн утгат үгээр ухаарч үл болно. Тэгээд ч “*хошой тавнан*” бол хоёр удаа гүнжтэй холбосон хүн биш, “*хошой чин ван*” бол хоёр удаа чин ван өргөмжлөгдсөн гэсэн үг биш нь тодорхой. Японы судлаач Абэ Кацуо энэ үгийн гарлыг хошуу гэдэг үгтэй холбосон аж<sup>59</sup>. Тэнгэрийн сүлдэтийн /T'ien-ming/ үед анх “хошой бэйл” гэдэг цол гарсан бөгөөд найман хошой бэйл найман хошууг захирч

<sup>59</sup> Энэ мэдээг [Kanda Nobuo.: On the *Beile* 貝勒 of the Early Ch'ing Dynasty // The Tōyō Gakuhō Reports of the Oriental Society, vol. XXXX. No. 4. March 1958. 7p.] өгүүллээс дам авав.

байжээ. Миний бодлоор энэ *hošoi* гэдэг нь манж хэлний өнцөг, зовхис гэсэн утгат *hošo* хэмээх үгийн харьяалахын тийн ялгал дахь /*hošo-i*/ хэлбэр юм. *Hošo* гэдэг үгийг өнцөг, зовхисоос гадна хязгаар нутаг гэсэн утгаар хэрэглэж байв. Эзэн хаан буюу улсыг төвлөн захирагчид хажуугаас түшин тус тусын хошууг захирагч гэсэн утгаар найман зовхисын бэйл гэж нэрийдсэнээс энэ үг гарчээ. Өөрөөр хэлбэл, хаан (төв) ↔ хошууны эзэн (зовхис) гэсэн утгын харьцаатай байна. Дээд эрдэмт /Ch'ung-te/-ийн үед хошой бэйл гэдэг цолыг халж, оронд нь хошой чин ван зэрэг цолыг бий болгов. Ердийн чин ван, тавнан ... зэргээс хошой гэсэн тодотголтой нь илүү зэрэгтэй байдаг тул яваандаа мөнөөх хошой гэдэг маань монголчуудад хүч нэмсэн, хоёр удаагийн гэсэн шиг утгаар ухагдахад хүрчээ. Үүнд нь, *qosiyaд* “хошоод”, *qosi* “хош” гэсэн монгол үгсийн гадаад хэлбэр ойролцоо нь нөлөөлсөн байна. Чингээд, *hoso-i* гэсэн манж үгтэй ижил хэлбэртэй (омоним), хоёр удаагийн, давхар гэсэн утгат монгол үг бий болсон ба манайд “хошой баатар”, “хошой аварга” гэх мэтээр хэрэглэж иржээ. “*Qošoi*” хэмээх үгийг монгол хэлний үүднээс бүтээврээр нь задлахад төгсгөл нь нэг л болохгүй, *qosi-үндэсний -si- үе -šo-* болчихсон байдгийн учир энэ буюу.

***yabsihiyan*** Монголоор гавшгай гэдэг. Цэргийн өмнө мэдээ авах, хэл барих, зам нээх, гүүр барих зэрэгт тушаасан хурц шилдэг цэргийг гавшгай гэнэ. Манж хэлний “*yabsihiyan*” монгол хэлэнд орохдоо “*yabsiyai*” хэлбэртэй болжээ. Монгол түүхийн сурвалжуудад “*busiyun*” /бушуу/ цэрэг гэж гардаг. 17 зууны үеэс “бушуу цэрэг”-ийг “гавшгай” цэрэг гэж манжаар хэлдэг болсон бололтой. Манжийн *гавсихиян* монгол хэлэнд орохдоо *шаламгай* гэдэг үгтэй адилсан /аналогиор/ уугуул монгол үг мэт хэлбэртэй болжээ.

Чин улсын цол хэргэмийн нэр нь Жүрчиний үеэс уламжлан ирсэн зүйл байхын хамтаар шинээр бий болгосон манж нэр томьёо, эрхшээн захирч байсан үндэстнүүдийн уламжлалт нэр томьёо гэсэн хэдэн зүйл байна. Чин улсад харьяалагдаж байсан үндэстнүүдийн хувьд эдгээрээс гадна манж нэр томьёог хуулбар орчуулгаар авч хэрэглэсэн зүйл нэлээд байжээ. Нэг хэсэг манж нэр томьёо бусад үндэстэнд ормол үг болж оржээ. Дашрамд дурдахад, манж хэлнээс монгол хэлэнд ормол бэйл, бэйс, занги, мэйрэн, залан, хүнд<sup>60</sup> гэх зэрэг үг байхаас гадна галдаа (<*yalai da* “гарын дарга”), үхэрдаа (<*uheri da* “бүгдийн дарга”), бойдаа (<*booi da* “гэрийн дарга”), бошго<sup>61</sup> (<*bošoqu* “хөөгч”), хурандаа (<*qūwaran-i da* “хорооны дарга”), хэбэй амбан (<*hebei amban* “хуувийн сайд”) зэрэг үгийг зарим газар орчуулж, зарим газар шууд авч хэрэглэсэн байдаг.

Жүрчин болон манж угсаатны түүхэн дэх цол хэргэм, албан тушаал, зэрэг дэвийн нэрсийн утга, гарал үүслийг цааш олон хэлний үүднээс харж нарийвчлан нягталбал, тэр нь эл хэлтний эртний нийгмийн харилцаа, улс төр, соёлын түүх төдийгүй, тэднээс хөрш зэргэлдээ оршиж ирсэн монгол, хятан, нангиад, солонгос зэрэг олон угсаатан лугаа харилцаж асан соёлын зарим асуудлыг судалж мэдэхэд олон чухаг сүвэгч, баримтыг нээн гаргах болзошгүй бөгөөд зайлшгүй анхааран үзвэл зохих асуудал болно.

<sup>60</sup> Орлон хөөгч, сумны зангийг орлогч.

<sup>61</sup> Хошуу тамга, сумын захиргааны газрын алба хөөж нийлүүлэгч, сумын зарлага.